



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/46

Мөрөн сум

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөвт
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.7, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Багийн хөгжлийг дэмжих төлөвлөгөө 3"-д туссан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсоргодог)-т даалгасугай.

3. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах 200,000,000 (Хоёр зуун сая) төгрөгийг, орон нутгийн хөгжлийн сангийн батлагдсан төсвөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Б.Оюунтуяа), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар) нарт, төлөвлөгдсөн арга хэмжээний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Мөнгөн-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 02 дугаар
сарын 07-ний өдрийн А/... дугаар
захирамжийн хавсралт

“БАГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 3”-ИЙН ХҮРЭЭНД
АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН
ХӨРӨНГӨӨР 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТӨГ

№	Үйл ажиллагаа	Тоо ширхэг	Шаардагдах хөрөнгө /сая. Төг/
1	Багийн Засаг дарга, багийн эмчийн унаажуулах	26	91,000,000
2	Багийн Засаг дарга, багийн эмчийг шаардлагатай компьютер, принтерээр хангах	26 40	109,000,000
Нийт дүн			200,000,000

_____оОо_____